



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 20 өдөр

Дугаар А/451

Булган сум

Гэрээ шууд байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1, Зохиогчийн эрхийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1, 36 дугаар зүйлийн 36.1.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Алтаргана 2024” олон улсын XV их наадмын “Туг өргөх баярын жагсаал”-ын үйл ажиллагааг бүрэн хариуцан зохион байгуулах ажлын гүйцэтгэгчээр “Асгатхалиун” ХХК-ийг сонгож, 48,400,000 (дөчин найман сая дөрвөн зуун мянга) төгрөгөөр гэрээ байгуулан, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Д.Жаргалсайхан)-д үүрэг болгосугай.

2. “Алтаргана 2024” наадмын туг өргөх баярын жагсаалын үйл ажиллагааг бүрэн хариуцан зохион байгуулалтыг мэргэжлийн өндөр түвшинд хийж гүйцэтгэхийг “Асгатхалиун” ХХК-ийн захирал (Т.Нансалмаа)-д даалгасугай.

3. Санхүүжилтийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн “Алтаргана 2024” арга хэмжээний төлөвлөгдсөн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6324010643